

# REACH

Small and Medium Enterprise Access to Credit

REACH CAP ТУТМЫН СОНИН

2017 оны 01 сар №9



## ЭНЭ УДААГИЙН ДУГААРТ:

1. REACH Төсөл 2016 онд
2. Амжилтын Түүх
3. Таны Мэдлэгт Булан
4. Зээлийн Боловсрол
5. Монгол Улсад Хэрэгжиж Буй Олон Улсын Байгууллагуудын Төслүүд
6. Зээлийн Зуучлал
7. Салбаруудад Болсон Онцлох Үйл Явдлуудаас
8. Бизнес Зөвлөгөө
9. REACH Төслийн 2017 оны 2 Сард Зохион Байгуулагдах Үйл Ажиллагааны Хөтөлбөр.


## ХОЛБОО БАРИХ:

REACH Төслийн оффис:


№ 703, МАКС Тауэр,  
Жуулчины гудамж 4-4, Чингэлтэй  
дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс

 +(976) 7722-2210 reach@dsmongolia.org www.dsmongolia.org www.facebook.com/REACHProject**Баян-Өлгий Оффис:**


№ 302 тоот, Гурван-Эрдэнэ Төв  
5-р баг, Өлгий сум, Баян-Өлгий аймаг

 Утас: 7042-2080**Дорнод Оффис:**


№ 11 тоот, Ольхон Худалдааны Төв,  
9-р баг, Хэрлэн сум, Дорнод аймаг

 Утас: 7058-2030**Дундговь Оффис:**

№ 205 тоот, Мандал Шилтгээн ХХК-ийн  
байр, 7-р баг, Бага тойруу, Сайнцагаан сум,  
Дундговь аймаг

 Утас: 7059-2209**Сэлэнгэ Оффис:**

№ 1 тоот, Алтан Булаг Төв  
Сүхбаатар сум, 2-р баг, Сэлэнгэ аймаг

 Утас: 7036-3440

## REACH ТӨСӨЛ 2016 ОНД



**АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID), Хөгжлийн Шийдэл ТББ-тай хамтран жижиг, дунд бизнесүүдийг санхүүгийн хувьд илүү бат бөх, тогтвортой үйл ажиллагаатай болоход шаардлагатай санхүүжилтийг банк, санхүүгийн байгууллагаас олж авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор REACH төслийг хэрэгжүүлж байна.**

### REACH ТӨСӨЛ НЭЭЛТЭЭ ХИЙВ

Улаанбаатар хот, Баян-Өлгий, Дорнод, Дундговь, Сэлэнгэ аймагт REACH Төсөл албан ёсны нээлтээ хийж, үйл ажиллагаагаа эхлүүлэв.



### REACH ТӨСЛИЙН ТҮНШЛЭЛ



REACH Төсөл төр болон хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох замаар жижиг, дунд бизнесүүдийг боломжит зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг авахад тавигдах шаардлагыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ХХААХҮЯ-ны ЖДҮХСан, ЗБДСан болон арилжааны банкнуудтай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурав.

### REACH ТӨСЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

REACH Төслийн сургалт, семинар, форум, уулзалт, зээлийн зуучлал, зөвлөх үйлчилгээнд давхардсан тоогоор 2465 жижиг, дунд бизнес /2016.12 сарын байдлаар/ хамрагдав.



### REACH ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН ЗУУЧЛАЛ



REACH Төсөл 20 тэрбум төгрөгийн зээлийн зуучлалын үйлчилгээ /2016.12 сарын байдлаар/ үзүүлэв.

### REACH ТӨСЛИЙН СУРГАЛТ

REACH Төсөл 72 удаагийн сургалт зохион байгуулж, 1019 жижиг, дунд бизнесийн төлөөлөл /2016.12 сарын байдлаар/ хамрагдав.



### REACH ТӨСЛИЙН АЖИЛ ХЭРЭГЧ УУЛЗАЛТ



REACH Төсөл 24 удаагийн ажил хэрэгч уулзалт зохион байгуулж, 590 жижиг, дунд бизнесийн төлөөлөл /2016.12 сарын байдлаар/ оролцов.

## АМЖИЛТЫН ТҮҮХ



### **Бизнесийн нэр:**

Самрын ясан дэр үйлдвэрлэл

### **Бизнес эрхлэгчийн овог, нэр:**

Ядамсүрэнгийн Хорол

Ядамсүрэнгийн Хорол нь 2015 оноос эхлэн Самрын ясан дэр үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр бизнес эрхэлж байна. Түүний бизнес санаагаа олсон түүх маш сонирхолтой.

Техник, технологи маш хурдацтайгаар хөгжиж буй одоо үед эдгээр техник тоног төхөөрөмжүүдийг удаан хугацаанд ашиглах явцад хүний нүдэнд харагдахгүй маш олон төрлийн хорт бодисууд ялгарч хүний биед сөргөөр нөлөөлж байдаг. Я. Хурал гэр бүл, эргэн тойрныхноо уг хорт нөлөөллөөс хамгаалах зорилгоор эрэл хайгуул, судалгаа хийж байх явцад хушны самар болон самрын ясны эмчилгээний гайхамшигт чанарын талаар олж мэджээ.

Ингээд тэрээр өөрөө болон гэр бүлийнхэндээ самрын ясаар дэр хийж нэлээдгүй хугацаанд хэрэглэж, туршиж үзсэний үндсэн дээр уг дэрний эмчилгээний шинж чанар, давуу талыг маш сайн

ойлгож авсан байна. Хорол энэхүү дэрийг зөвхөн өөрөө хэрэглээд зогсохгүй бусад хүмүүст хэрэглүүлж техник, технологийн хорт нөлөөллийг бага ч болов саармагжуулах зорилгоор ясан дэрийг үйлдвэрлэн зах зээлд нийлүүлэхээр уг бизнесээ эхлүүлсэн түүхтэй.

Самар манай улсад их хэмжээгээр ургадаг боловч дотооддоо уг бүтээгдэхүүнийг ашиглан үйлдвэрлэл явуулах нь маш бага. Харин самрыг цөмөн идээг нь Хятад улсруу гаргаж, самрын яс нь бараг хаягддаг байна. Гэтэл гадаадын зарим улс орнууд самрын ясан дэрний ач холбогдлыг ойлгон өндөр үнээр борлуулдаг ба Монголчууд ч гаднаас уг бүтээгдэхүүнийг худалдан авах явдал их байдаг аж.

Хорол цаашид бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэх улмаар бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэн бүтээгдэхүүнээ гадаад зах зээлд гаргах зорилготой. Тэрээр энэ зорилгодоо хүрэхийн тулд үйлдвэрлэлээ өргөжүүлэх санхүүжилт авах хүсэлтэй байгаа бөгөөд энэ тал дээр мэргэжлийн зөвлөгөө, мэдээлэл өгөх суваг эрж хайсны үр дүнд АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн зүгээс Хөгжлийн Шийдэл

ТББ-тай хамтран хэрэгжүүлж буй REACH Төслийн талаар мэдээлэлтэй болж төслийн Улаанбаатар оффист хандсан юм.

Я.Хорол, *“REACH төслийн сургалтад хамрагдсанаар бизнес төсөл яаж бичих, бизнес хийхдээ юу, юуг судалж, зах зээлийн судалгааг хэрхэн хийх, төслийн зээлүүдэд яаж хамрагдах, авсан зээлээ хэрхэн, яаж үр ашигтай зарцуулах гэх мэт маш олон зүйлсийг сурч авсан минь зорилгодоо хүрэх чухал алхмуудын нэг боллоо”* гэв.

REACH Төслийн сургалтад хамрагдсан жижиг, дунд бизнесүүд бизнес төсөл бичиж сурахаас гадна бизнесээ сайжруулах, санхүүгээ удирдах арга барилд суралцах, Монгол улсад хэрэгжиж буй ОУ-ын төсөл хөтөлбөрүүд болон арилжааны банкнуудын зээлд хэрхэн хамрагдаж болох талаар цогц мэдлэг олгодог юм. REACH Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш нийт 5 салбараараа дамжуулан 72 удаагийн сургалт зохион байгуулж, үүнд 1019 жижиг, дунд бизнесүүдийн төлөөллийг /2016.12 сарын байдлаар/ хамруулаад байна.





## ТАНЫ МЭДЛЭГТ БУЛАН



### ШИНЭЧЛЭЛ

Бизнес гэдэг бол амьд амьтантай адил өснө, агшина, өөрчлөгдөнө. Бизнесээ тогтмол шинэчилж байх нь таны заавал хийх ёстой зүйл. Хувьсан өөрчлөгдөж буй орчин нөхцөлд бизнесээ зохицуулахын тулд, эсвэл шинэ шинэ арга барил, чадварт суралцахын тулд.

### ТӨВЛӨР

Төлөвлөгөөтэй бай, яг юу зарахаа шийд, түүнийгээ цаасан дээр буулга. Энэ нь таньд бодож байгаа зүйл ээ цэгцтэйгээр харах боломж олгоно, мөн таныг тэр бодлын хажуугаар төрөх янз бүрийн асуудалд төөрөлдөхөөс хамгаална. Бүтэц, зохион байуулалт бол бизнест маш чухал. Юунд хүрэхийг хүсч байна? Юу хэрэгтэй байна? Ямар зардал таниас шаардах вэ? Бизнес төлөвлөгөө бичих нь таныг бизнестээ анхаарлаа төвлөрүүлж, орлого болон зардалаа шинжилж үзэх гарцаагүй байдалд оруулдаг сайн талтай.

### БҮХНЭЭ ЗОРИУЛДАГ АЖИЛТАН БҮХНИЙ ТҮЛХҮҮР

Байгууллагын амжилт ажилтнуудаас хамаардаг. Нөхөрсөг, үнэнч шударга уур амьсгал нь бүтээгдэхүүн процесс сайжирч шинэчлэгдэх таатай орчныг бий болгодог. Сайхан сэтгэл, хичээл зүтгэл, бүхнээ зориулахад бэлэн байдал л шинэчлэлийг амжилтанд хүргэх замыг дардан болгоно.

### БҮТЭЭЖ БАЙГААГААРАА БАХАРХДАГ БАЙ

Хэрэв та болон танай ажилтнууд өөрсдөө бахархахаар бүтээгдэхүүн бүтээж чадаж байгаа бол та бүхэн борлуулалтдаа амжилт олох нь гарцаагүй. Энэ нь бүтээгдэхүүндээ төвлөрөх, анхаарал халамж тавихыг та бүхнээс шаардана. Үйлдвэрлэлийн орчин цэвэр цэмцгэр, зөв дэс дараатай, ажилтнууд аюулгүй ажилладаг бол бүтээгдэхүүн тэр хэмжээгээр чанартай байна. Улмаар ажилчид сайн бүтээгдэхүүн үйлвэрлэснээрээ бахархах сэтгэлтэй болох болно.

### СОНИУЧ ЗАНГИЙН ЕРӨНХИЙ МЭДРЭМЖТЭЙ БОЛ

Байгууллагын шинэчлэлд байгууллагын эзний хувиар та онцгой үүрэгтэй. Та байнга шинэчлэл, хөгжилд анхаарал тавьдаг бол танай ажилтнууд ч мөн тийм болж хүмүүжинэ. Хэрэв та өөрчлөлт шинэчлэлийг огт хүсдэггүй бол таны эргэн тойронд юм бүхэн бахь байдгаараа л үлдэнэ, ямар ч шинэчлэл, хөгжил хэзээ ч ирэхгүй.

### ШИНЭЧЛЭЛ САХИЛГА БАТ ШААРДДАГ

Шинэчлэл өөрөө ирнэ гэж хэзээ ч байхгүй. Нэг юмуу нэлээн хэдэн ажилтан шинэчлэлийн төлөө ажлын цагийнхаа нэлээдгүй хэсгийг зарцуулах нь чухал. Таны бизнес их амжилттай яваа тохиолдолд ч энэ нь хамаатай. Зах зээлд болж байгаа ямарваа өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлэхэд та байнга бэлэн соргог байх хэрэгтэй.

### ЭРСДЭЛТЭЙ АЛХАМ ХИЙХИЙГ ЗОРЬ

Бизнес эхлэнэ гэдэг бол эрсдэл хүлээхэд бэлэн байна гэсэн үг. Шинэчлэлийн тухайд ч мөн адил. Танай байгууллагад бий болсон ямар нэгэн шинэчлэлийн тухай санаа сэдэл нь танай үйлчлүүлэгчдээс хүсэн хүлээсэн зүйлтэй тохирч байгаа тохиолдолд илүү амжилттай болох магадлалтай. Зах зээл юу хүсч байгааг мэдэрдэг байхыг хичээ. Та өөрийгөө худалдан авагчдын оронд тавиад, тэд юу хүсч байгааг тэдний хайж байгаа зүйлийн давуу тал юу болохыг бодож ол.

### ИТГЭЖ БОЛОХ ЧӨЛӨӨТЭЙ ХАРИЛЦДАГ ТҮНШТЭЙ БОЛ

Таны бизнес хувийн ямар нэг сонирхолын зөрчилгүй, та түүнтэй нээлттэй чөлөөтэй ярьж зөвлөж болох тийм хүнийг олж авах хэрэгтэй. Мэдлэгтэй, асуултыг зөв тавьж чаддаг, танд ахиж хөгжихөд дэм болох тийм хүн. Хэрэв та ямар ч асуулт, зөвлөгөөг хүлээж авахад бэлэн байгаа бол та үүнийг хий, таны зорьсон шинэчлэл, хийсэн үйл илүү үр дүнтэй байж таныг улам хүчирхэг болгоно.

### ИТГЭЖ БОЛОХООР БАЙ, БУСДААС ЯЛГАР, ИЛҮҮ ГАР

Үйлчлүүлэгчид амласан л бол хэлсэндээ хэзээд хүрч бай. Энэ бол амин чухал. Хэзээд итгэлтэй байх нь танд ашигтай, таныг үнэ цэнээ алдаж хүндрэлд орохоос хамгаална. Өрсөлдөгчид тань тантай өрсөлдөхүйц бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлдэг байж болно, гэхдээ та тэндээс цаг хугацааг нарийн чанд барьдаг тогтвортой чанарын дээдийг амладгаараа ялгаргаж байх хэрэгтэй. Энэ нь таны бизнесийн бат бөх суурь болохоос гадна бүтээгдэхүүнээ байнга сайжруулж байх хэрэгтэй.

*Компани өргөжүүлхийг хүсч байгаа л бол үүнд хариуцлагатай ханд. Та бизнесийнхээ эргэлтийг нэг дор хоёр дахин өсгөж чадахгүй ч дараа жил гэхэд эргэлтээ арван хувиар өсгөх зорилт тавьж яагаад болохгүй гэж.*

*Эх сурвалж: PUM Бизнес эрхлэгч эздэд зориулсан сургаж, зөвлөмж. Гарын авлага 66-69 хуудас*



## 4.ЗЭЭЛИЙН БОЛОВСРОЛ

### ЗЭЭЛДЭГЧИЙН СОЁЛ

Бид бизнесийн үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн эх үүсвэрийн дутагдалтай үргэлж тулгарч байдаг. Бизнес зайлшгүй шаардалагатай санхүүжилтийг босгохын тулд бизнес эрхлэгчид банк санхүүгийн байгууллагуудад хандаж санхүүгийн асуудалаа шийдвэрлэдэг билээ. Ингээд та аль нэг банкны эдийн засагчид зээлийн хүсэлт тавьдаг, харин банкны эдийн засагч таньд бүрдүүлэх материалын жагсаалттай хуудас өгч түүний дагуу зээлийн материал аа бүрдүүлдэг. Гэвч материал бүрдүүлэх явцад мэдэхгүй чадахгүй зүйлстэй нэлээд их тулгардаг, үүнээсээ болоод бизнесүүд хүссэн санхүүжилтээ бүтэн авч чадахгүйд хүрэх тохиолдол ч байдаг. Тиймээс бизнес эрхлэгчид дараах зүйлсийг бизнесийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллавал дээрх бэрхшээлүүдийг ажрахгүй болно. Үүнд:

- Орлогоо баталгаажуулж байх
- Зардалаа тогтмол бүртгэж хэвших
- Арилжааны банкт харилцдаг байх
- Хуримтлалтай байх
- Бизнесийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийн бүрдлийг бэлэн байлгах.



### ЗЭЭЛИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ АШИГЛАХ

Банкнаас авсан зээлээ зориулалтын дагуу ашиглах ёстойг бид тэр бүр мэдэдгүй. Хувь хүн, байгууллага, Засгийн газар бүгд зээл авч ашигладаг. Ямар нэг зүйл худалдан авах, бизнес эрхлэх, өргөжүүлэхэд өөрийн мөнгө, хөрөнгө хүрэлцэхгүй үед бусдаас эргүүлж төлөх нөхцөлтэйгөөр авч ашиглаж буй мөнгийг зээл гэж нэрлэдэг. Зээлийн үйл ажиллагаа нь зээлдэгч, зээлдүүлэгч хоёр талын харилцааны явцад хэрэгждэг.

Зээл авах нь давуу болон сул талтай. Хэрэв зээлийг зориулалтын дагуу ашиглаж чадвал үр ашигтай боловч зориулалтаар бус ашиглах, эргэн төлж чадах хэмжээнээс хэтрүүлэн зээл авах нь эрсдэлийг дагуулна. Иймээс зээлийг тодорхой зориулалттайгаар олгодог. Зээлийн зориулалт нь зээлийн нөхцөл, хүү, хэмжээг тогтоох үндэс болдог.

Тэгвэл зээлийг зориулалт бусаар ашиглах нь дараах сөрөг үр дагавартайг анхаарна уу?

- Таны төлөвлөсөн бизнесийн үйл ажиллагаа доголдоно.
- Бизнесийн эргэлтийн хөрөнгө буурснаар тооцоолсон орлого орж ирэхгүй.
- Орлого буурснаар зээлийн эргэн төлөлт өө хийхэд хүндрэл учирна.
- Банк болон төслийн зээлээр санхүүжилт авсан тохиолдолд улирал тутамд зээлийн эргэн хяналт хийдэг бөгөөд зээл зориулалт бусаар ашиглагдсан тохиолдолд зээлийг буцаан татах болно.

Иймээс та зээлийг өр биш үйл ажиллагаагаар өргөжүүлэх боломж болгон харж, бизнесийн үйл ажиллагаанд зориулан авсан зээлээ зориулалтын дагуу ашиглавал таны бизнесийн үйл ажиллагаанд ямар нэг доголдол үүсэхгүй бөгөөд харин ч эсрэгээрээ бизнесийн үйл ажиллагаа өргөжинө гэдгийг санаарай.

Эх сурвалж: [www.bizguide.mn](http://www.bizguide.mn)



## МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖИЖ БҮЙ ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨСЛИЙН ЗЭЭЛҮҮД

### ХАСБАНКИНД ОЛГОГДОЖ БҮЙ IFC (ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН КОРПРАЦИ)-ИЙН ЗЭЭЛ

ЖДҮ ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООТОЙ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ.

#### 1. БИЗНЕС ХЭРЭГЖҮҮЛЭГЧ НЬ:

- Хувийн өмч давамгайлсан ( $\geq 51\%$ ) ААН, байгууллага байх (хувьцаат компаний хувьд саналын болон саналын эрхгүй нийтэд санал болгосон хувьцаа 49 хувиас ихгүй байх);
- Монгол улсын хууль тогтоомж, Банкны дотоод журмын дагуу хориглосон үйл ажиллагаа явуулдаггүй байх,
- Тухайн байгууллагын 51% эзэмшлийн түүнээс дээш хувийг эмэгтэй эхсүл эмэгтэйчүүд эзэмшдэг байх;
- Дараах шалгууруудаас хоёроос доошгүйг хангасан байх,
- Жилийн нийт борлуулалтын орлого 15.00 сая ам.доллараас бага байх;

#### 2. БИЗНЕС ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ:

- Нийт хөрөнгө 15.00 сая ам.доллараас бага байх;
- Нийт ажиллагсдын тоо 300 –аас бага байх.

Үзүүлэлт	Нөхцөл
Зээлийн хэмжээ	25 саяас 2,5 тэрбум төгрөг хүртэл
Зээлийн хүү	16,8%-22,8%
Зээлийн хугацаа	5 жил хүртэл



## 6. ЗЭЭЛИЙН ЗУУЧЛАЛ

Манай өмнөх дугааруудад танд бизнесийн зээлийг хэрхэн авах, ямар бичиг баримт бүрдүүлэх, банкаа хэрхэн сонгох, зээл авах дараалал, үе шатуудын талаар мэдээлж байсан бол энэ удаад **ЗЭЭЛИЙГ ХЭРХЭН ҮР АШИГТАЙ ЗАРЦУУЛАХ** талаар дараах зөвлөгөөг хүргэе.

1. Бизнес төлөвлөгөөний үе шаттай уялдуулж зээлжих.
2. Зээлийг эргэн төлөхийг тооцоолох.
3. Өөрийн хүссэн зээлийг гаргуулах.

# 2

Зээлийн хэмжээ, хугацааг зөв тогтоогоогүйгээс бизнес хаалгаа барихад хүрэх ч тохиолдол байдаг. Тухайлбал бизнес төлөвлөгөөний үе шатанд хамаарахгүй авсан зээл нь сул хүүний зардалыг өсгөж байгааг анзаарахгүй хэнэггүй царйлдэг. Энэ нь ашгийн түвшингээс чинь хулгайлсан хэрэг юм. Бизнесийн эхлэлтийн үе шат, нэвтрэх үе шат, таниулах үе шатны борлуулалтын түвшин харьцангуй бага байхад бусад үе шаттай ижилхэн хэмжээний зээлийн төлбөр тавих нь санхүүгийн дарамтанд оруулж байгаа нууц хавч юм.

## ЗЭЭЛИЙН ҮР АШИГ

# 1

Шинэ бизнес эхлүүлэх үед мөнгөтэй байх нь маш чухал бөгөөд үүнийгээ зөв зарцуулах нь чухал. Тухайлбал бизнесийн эзэн зээлийг нэг удаа бөөн авах гэж улайрах. Энэ нь санхүүгийн дарамтанд орох хамгийн энгийн алхам болдог. Манай улсын арилжааны банкуудын зарим нь үе шаттай зээл олгодоггүйгээс үүдэн бизнес эрхлэгчид нэг дор шаардлагатай бүх зээлийг гаргуулан авч алдаа гаргах нь олонтой. Таны бизнес төлөвлөгөөний үе шат бүрт ямар санхүүжилт шаардлагатай түүнийгээ тухай бүр нь шийдэх боломжийг эрэлхийлэх шаардлагатай. Бизнесийг санаачлагч нь тухайн бизнестээ их хэмжээний мөнгийг зарцуулаад үр дүнг нь хурдан харахыг хорхойсож байж болзошгүй. Ингэсэн тохиолдолд мөнгийг зөв зүйлд зарцуулахаасаа илүүтэй өөрийнхөө хүссэн зүйлд зарцуулчихсан байдаг нь энэхүү алдааны төлөөс юм.

# 3

Өөрийн бизнест ямар хэмжээний санхүүжилт хэрэгтэй байгааг тооцоолсон ч гаргуулж чаддаггүй. Барьцаа хөрөнгө байхгүй, өөрт тохирсон зээлийн бүтээгдэхүүнийг сонгож чадаагүй, танд туслах банкыг сонгоогүйгээс ихэнх бизнес эрхлэгчид хүссэн санхүүжилтээ гаргуулж авч чаддаггүй. Банкны эдийн засагчийн, тухайн зээлийн хорооны шийдвэрлэсэн хэмжээгээр зээлээ аваад хөнжлийнхөө хэрээр хөлөө жийх болдог. Үүнээс болж та хүссэн бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж чадахгүй, хүссэн тоног төхөөрөмжөө авч чадахгүйд хүрдэг. Гэвч зээл олгогдсон, зээлийн хүү бодогдоод эхэлсэн байдаг. Иймд та өөрт тохирсон зээлийн бүтээгдэхүүн, танд шаардлагатай дэмжлэгтэй /зээлийн батлан даалтын сан/, мөн туслах чадвартай банкыг сонгож үйлчлүүлэх нь бас нэг ахих шат юм.

Эх сурвалж: [www.mongo.mn](http://www.mongo.mn)

## 7. САЛБАНУУДАД БОЛСОН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУДААС

### БАЯН-ӨЛГИЙ САЛБАР

2016.12.12-нд REACH төслийн Баян-Өлгий салбар ээлжит сургалтаа “Тооцоолох цаг-II” сэдвээр зохион байгууллаа. Тус сургалтанд ХААН банкны Баян-Өлгий салбарын харилагчид оролцов. Сургалтаар ЖДБ-дэд бизнесийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлж, санхүүгийн тайланг уншиж ойлгох, санхүүгийн шинжилгээ хийж бизнесийн үйл ажиллагааг төлөвлөх арга техникийн талаар мэдлэг олгов. Түүнчлэн ХААН банкны ЗБХ Менежер С.Серик кредит картны талаар, БХМенежер Ш.Серикболат Бизнесийн зээлийн талаар мэдээлэл хүргэв.



### ДОРНОД САЛБАР

2016.12.08-нд Дорнод салбар тус аймгийн ИТХ-ын Байгаль орчин, Аялал жуулчлалын бодлогын хороотой хамтран уулзалт зохион байгуулав. Тус уулзалтад Дорнод аймагт аялал жуулчлалын чиглэлээр бизнес эрхэлдэг бизнесүүд аймгийн аялал жуулчлалын системийг байгуулж, хэрхэн харилцан ашигтай хамтран ажиллаж, нэгдсэн зохион байгуулалтад орох тухай ярилцав. Уулзалтад аймгийн ИТХ-ын Байгаль орчин, Аялал жуулчлалын бодлогын хорооны гишүүд, ЗДТГ-ын ХОХБХ-ийн дарга, мэргэжилтэн, оюутан, судлаач багш, ХАҮТ-ын дарга нар оролцлоо. Уулзалтын үр дүнд тус салбарт үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, иргэд 7 хоног бүр уулзаж системийн бүтэц, үйл ажиллагааг илүү боловсронгуй болгож харилцан ашигтай байх тухай ярилцаж байхаар боллоо.



### ДУНДГОВЬ САЛБАР

REACH Төслийн Дундговь салбар ээлжит сургалтаа “Бизнес төлөвлөгөө боловсруулах аргачлал” сэдвээр 2016.12.07-нд зохион байгуулж 2017 он гармагц Сум хөгжүүлэх сан төслийн зээлийн санал авч эхлэхтэй холбогдуулан өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг бизнесүүдийг оролцуулсан сургалтыг явууллаа. Уг сургалтанд ХасБанкны Дундговь салбарын захирал Ч.Түяацэцэг оролцож ХасБанкны зээлийн бүтээгдэхүүний талаар мэдээлэл хийж, тус сургалтанд оролцсон бизнесүүдэд ХасБанкнаас бизнесийн зээлийн хүүг дээд хүүнээс 0,2%-аар бууруулж авах эрх олгосноороо онцлог боллоо.



### СЭЛЭНГЭ САЛБАР

2016.12.07-нд Сэлэнгэ аймгийн Мандал суманд үйл ажиллагаа явуулж буй ЖДБ эрхлэгчдэд Хаан Банк, Төрийн банк, Голомт Банк, ХасБанк, Капитал Банктай хамтран Зээлийн боловсрол олгох сургалтыг амжилттай зохион байгууллаа. Тус сургалтаар ЖДБ-үүдэд зөвхөн санхүү зээлийн боловсрол олгоод зогсохгүй зээлийн зуучлалын үйлчилгээ үзүүлэв.





## 8. БИЗНЕС ЗӨВЛӨГӨӨ

## ХУРИМТЛАЛ ХЭРХЭН ҮҮСГЭХ ВЭ?

## Танд мөнгөн хуримтлал бий юу?

Бид өөрийн олж буй мөнгөнийхөө хэдэн хувийг хадгалах, юунд хадгалах талаараа бодсон зүйлгүйгээс орж ирсэн орлогоо хуримтлал үүсгэлгүйгээр зарцуулаад дуусдаг. Нэг ёсондоо орлого өссөн зардал мөн өссөн үзүүлэлтээр таны орлого 50,0 байсан 100,0 байсан ч та хуримтлал үүсгээгүй бол хоёрын хооронд хэрэглээ нэмэгдэж, эцсийн дүнд таны олсон орлого 0 болдог. Тэгэхээр бид ихэнхдээ хуримтлал хийх боломжтой боловч түүний ач холбогдол өгөөжийн талаар сайн ойлголтгүй учраас хуримтлал хийдэггүй.

## Хуримтлал үүсгэх алтан дүрэм:

- Орлого тэгээс их
- Зарлагаа хэмнэх
- Тасралтгүй хуримтлуулах
- Олсон орлого бүрийнхээ 10%-г хадгалах.



## Хуримтлалын давуу талууд:

- Орлого буурах үед хуримтлал орлого бий болгодог.
- Эрсдэлээс хамгаална.
- Гэнэтийн санхүүгийн хэрэгцээг шийдвэрлэнэ.
- Зөв хэрэглээнд сургана.
- Ирээдүйдээ итгэх итгэлийг бий болгодог.

Та хүссэн хэмжээний хуримтлалыг бий болгоход шаардагдах хугацааг тооцохыг хүсвэл, хүссэн хэмжээний хуримтлалыг бий болгоход сар бүр хадгаламжинд орлогодох мөнгөн дүнг тооцохыг хүсвэл доорх хаягаар нэвтэрч хуримтлалын тооцоолуураа хийж үзээрэй.

## 9. REACH ТӨСЛИЙН 2 САРД ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

- 2017.02.14-16 Улаанбаатар хот “Бизнес Төсөл Боловсруулах Аргачлал”, “Санхүүгийн Тайланг Уншиж ойлгох нь”, “Санхүүгийн Тайлангийн Шинжилгээ ба Хэрэглээ”, “Зээлийн Боловсрол” сэдвээр сургалт
- 2017.02.14 Сэлэнгэ салбарт ЖДБ-дэд зориулсан “Санхүүгийн тайланг уншиж ойлгох нь” сэдвээр сургалт.
- 2017.02.15 Дундговь салбарт ЖДБ-дэд зориулсан “Санхүүгийн тайланг уншиж ойлгох нь” сэдвээр сургалт.
- 2017.02.16 Дорнод салбарт “Санхүүгийн тайланг уншиж ойлгох нь” сэдвээр сургалт.
- 2017.02.17 Баян-Өлгийн салбар ЖДБ-дэд зориулсан “Санхүүгийн тайланг уншиж ойлгох нь” сэдвээр сургалт.

## Та дээрх сургалт, уулзалтанд бүртгүүлэх бол:

- **Улаанбаатар Оффис:**  
№: 703, МАКС Тауэр, Жуулчины гудамж 4-4, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Утас: 7722-2210, И-мэйл: reach@dsmongolia.org
- **Баян-Өлгий Салбар**  
№ 302 тоот, Гурван-Эрдэнэ Төв 5-р баг, Өлгий сум, Баян-Өлгий аймаг. Утас 7042-2080
- **Дундговь Салбар**  
№ 205 тоот Мандал Шилтгээн ХХК-ийн байр, 7-р баг, Бага тойруу, Сайнцагаан Сум, Дундговь аймаг. Утас 7059-2209
- **Дорнод Салбар**  
№11 тоот, Ольхон Худалдааны Төв, 9-р баг, Хэрлэн сум, Дорнод аймаг. Утас 7058-2030
- **Сэлэнгэ Салбар**  
№1 тоот, Алтан Булаг Төв, Сүхбаатар сум, 2-р Сэлэнгэ аймаг. Утас 7036-3440

[www.xacbank.mn](http://www.xacbank.mn)
[www.statebank.mn](http://www.statebank.mn)
[www.khanbank.mn](http://www.khanbank.mn)
[www.golomtbank.mn](http://www.golomtbank.mn)

"Энэхүү сонинг АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (ОУХА)-аар дамжуулан Америкийн ард түмний өгөөмөр дэмжлэгтэйгээр бүтээсэн болно. Хөгжлийн Шийдэл ТББ нь сонинтой холбоотой хариуцлагыг бүрэн хүлээх бөгөөд үүнд АНУ-ын Засгийн Газар болон АНУ-ын ОУХА-ийн үзэл бодлыг илэрхийлээгүй болно."